



ТОГТВОРТОЙ  
ХӨГЖЛИЙН  
ЗОРИЛГУУД

“НҮБ-ын гишүүн 193 орны шийдвэрээр 2030 он хүртэлх Тогтвортой хөгжлийн зорилгуудыг 2015 онд баталсан бөгөөд эдгээр зорилгууд нь ядуурлыг устгах, тэгш бус байдлыг халж, эх дэлхийгээ хамгаалах, хүний тайван амгалан амьдрах эрхийг хангах зэрэг өргөн хүрээний асуудлуудыг хамарсан юм. Мянганы хөгжлийн зорилгуудын үргэлжлэл болох эдгээр 17 зорилгууд “хэнийг ч, хаана ч орхигдуулахлагүй”-ээр тогтвортой хөгжилд хүрэх болно.

Дэлхийн Тогтвортой хөгжлийн зорилгуудтай уялдуулан “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-ыг УИХ-аараа 2016 онд баталсан билээ. Засгийн газраас зорилгуудын хэрэгжилтийг эрчимжүүлэх салбар, бодлогын тэргүүлэх чиглэлийг оновчтой тогтоож, төсвийн хөрөнгийн хуваарилалтыг уялдуулахад анхаарч хөгжлийн түншүүдтэйгээ хамтран ажиллаж байна. Энэ хүрээнд дараах чиглэлээр ажлуудыг эрчимжүүлэх хэрэгтэй байна:

- Урт хугацааны хөгжлийн бодлогыг дунд хугацааны болон салбарын тэргүүлэх чиглэлтэй уялдуулах, бодлогын хэрэгжилтийг зохицуулах тогтолцоо механизмыг сайжруулах
- Бодлогын тэргүүлэх чиглэлийг үндэслэн төсвийн хөрөнгийн хуваарилалт болон бусад санхүүжилтийн эх үүсвэрийг төвлөрүүлэх,
- Олон улсад хүлээн зөвшөөрсөн болон үндэсний үзүүлэлтийг үндэслэн хяналт-шинжилгээ, үнэлгээг гүйцэтгэх зэргийг төр болон иргэний нийгэм хамтаараа хэрэгжүүлэх.





ТОГТВОРТОЙ  
ХӨГЖЛИЙН

ЗОРИЛГУУД

1 ЯДУУРЛЫГ  
УСТГАХ



Ядуурлын  
бүх хэлбэрийг  
эцэс болгох

*Таны оролцоо: Өөрийн хэрэглэхгүй байгаа зүйлсээ хандивла. МУ-ын нийт хүн амын 1/3 нь ядуу байна.*



ТОГТВОРТОЙ  
ХӨГЖЛИЙН

ЗОРИЛГУУД

2 ӨЛСГӨЛӨНГ  
ЗОГСООХ



Өлсгөлөнг эцэс болгож,  
хүнсний аюулгүй байдлыг  
хангах тэжээллэг чанарыг  
нэмэгдүүлж, хөдөө аж  
ахуйн тогтвортой өсөлтийг  
хөхиүлэн дэмжих

*Таны оролцоо: Хоол хүнс хаяхаас зайлсхий. Дэлхий  
дахинд нийт хоол хүнсний 1/3-ээс их нь хаягдаж  
байна.*



ТОГТВОРТОЙ  
ХӨГЖЛИЙН

ЗОРИЛГУУД

3 ЭРҮҮЛ МЭНДИЙГ  
ДЭМЖИХ



Нийт хүн амыг  
эрүүл, сайн сайхан  
амьдрах нөхцөлөөр  
хангах

*Таны оролцоо: Тамхи татахаа зогсоож, согтууруулах ундааны хэрэглээг хязгаарлан эрүүл хоол хүнс хэрэглэж, дасгал хөдөлгөөн байнга хий. Эмчийн зааваргүйгээр антибиотик бүү хэрэглэ.*



ТОГТВОРТОЙ  
ХӨГЖЛИЙН

ЗОРИЛГУУД

## 4 ЧАНАРТАЙ БОЛОВСРОЛЫГ ДЭМЖИХ



Хүн бүрт чанартай  
боловсролыг тэгш хүргэх,  
насан турш сурч боловсрох  
боломжийг бүрдүүлэх

*Таны оролцоо: Өөрийн амьдардаг орон нутагт  
хүүхэд бүр чанартай боловсрол эзэмшихэд нь тусал.*



ТОГТВОРТОЙ  
ХӨГЖЛИЙН

ЗОРИЛГУУД

**5** ЖЕНДЭРИЙН  
ЭРХ ТЭГШ  
БАЙДЛЫГ  
ХАНГАХ



Жендэрийн эрх тэгш  
байдлыг хангах, охид  
эмэгтэйчүүдийн эрх  
мэдлийг нэмэгдүүлэх

*Таны оролцоо: Аль нэг хүйсийг дорд үзсэн үг хэллэг, зан  
үйлийг эсэргүүц.*



ТОГТВОРТОЙ  
ХӨГЖЛИЙН

ЗОРИЛГУУД

**6** БАТАЛГААТ  
УНДНЫ УС,  
АРИУН ЦЭВРИЙН  
БАЙГУУЛАМЖААР  
ХАНГАХ



Нийт хүн амыг баталгаат  
ундны ус, сайжруулсан  
ариун цэврийн  
байгууламжаар хангах

*Таны оролцоо: Усыг хэмнэ. Монголын нийт хүн амын  
64% нь л сайжруулсан усны эх үүсвэртэй байна.*





ТОГТВОРТОЙ  
ХӨГЖЛИЙН

ЗОРИЛГУУД

7 СЭРГЭЭГДЭХ  
ЭРЧИМ  
ХҮЧИЙГ  
НЭВТРҮҮЛЭХ



Нийт хүн амыг  
хямд, найдвартай,  
тогтвортой, орчин  
үеийн эрчим хүчээр  
хангах

*Таны оролцоо: Зөвхөн эрчим хүчний хэмнэлттэй цахилгаан хэрэгсэл, гэрлийн шилийг ашигла. Мөн хэрэглээгүй үедээ цахилгаан хэрэгслээ унтрааж бай.*



ТОГТВОРТОЙ  
ХӨГЖЛИЙН

ЗОРИЛГУУД

**8** **ЗОХИСТОЙ ХӨДӨЛМӨР  
БА ЭДИЙН ЗАСГИЙН  
ӨСӨЛТИЙГ ДЭМЖИХ**



Хүртээмжтэй, тогтвортой  
эдийн засгийн өсөлт  
болон бүх нийтийн бүрэн,  
бүтээмжтэй, зохистой  
хөдөлмөр эрхлэлтийг дэмжих

*Таны оролцоо: Усыг хэмнэ. Ажилчиддаа тэгш боломжийг олгодог байгаль орчинд ээлтэй компаниудаас худалдан авалтаа хий.*



ТОГТВОРТОЙ  
ХӨГЖЛИЙН

ЗОРИЛГУУД

## 9 ИННОВАЦИ БОЛОН ДЭД БҮТЦИЙГ ХӨГЖҮҮЛЭХ



Найдвартай дэд бүтэц,  
хүртээмжтэй, тогтвортой  
аж үйлдвэрийг хөгжүүлэх,  
инновацийг хөхүүлэн  
дэмжих

*Таны оролцоо: Хуучин эд материалыг дахин  
ашиглалтанд оруулах шинэлэг арга замыг бодож ол.*



ТОГТВОРТОЙ  
ХӨГЖЛИЙН

ЗОРИЛГУУД

**10** ТЭГШ БУС  
БАЙДЛЫГ  
БУУРУУЛАХ



Улс орнуудын дотоод  
дахь болон улс  
хоорондын тэгш бус  
байдлыг багасгах

*Таны оролцоо: Ялгаварлан гадуурхалтын эсрэг дуу  
хоолойгоо сонсго.*



ТОГТВОРТОЙ  
ХӨГЖЛИЙН

ЗОРИЛГУУД

11 ЭЭЛТЭЙ ХОТ,  
ИРГЭДИЙН  
ОРОЛЦООГ  
ДЭМЖИХ



Хот, суурин газруудын  
тэгш, хүртээмжтэй,  
аюулгүй, тогтвортой  
хөгжлийг дэмжих

*Таны оролцоо: Хотынхоо агаарыг цэвэр байлгахын тулд дугуй уна. явган алх эсвэл нийтийн тээврийг ашигла.*



ТОГТВОРТОЙ  
ХЭГЖЛИЙН

ЗОРИЛГУУД

12 ХАРИУЦЛАГАТАЙ  
ХЭРЭГЛЭЭГ  
ДЭМЖИХ



Хариуцлагатай,  
тогтвортой хэрэглээ  
болон үйлдвэрлэлийг  
дэмжих

*Таны оролцоо: Цаас, хуванцар, шил, хөнгөн цагаан материалыг дахин боловсруул.*



ТОГТВОРТОЙ  
ХӨГЖЛИЙН

ЗОРИЛГУУД

# 13 УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ҮР НӨЛӨӨГ БАГАСГАХ



Уур амьсгалын  
өөрчлөлт, түүний  
сөрөг нөлөөллийг  
багасгах арга  
хэмжээг яаралтай  
авах


*Таны оролцоо: Түүхий нүүрсний хэрэглээг багасга, мөн хог бүү шатаа. 2010 оноос хойш Монголд нүүрстөрөгчийн ялгаруулалт гурав дахин ихэссэн байна.*



ТОГТВОРТОЙ  
ХӨГЖЛИЙН

ЗОРИЛГУУД

14 ДАЛАЙ  
ТЭНГИСИЙН  
НӨӨЦИЙГ  
ХАМГААЛАХ



Далай тэнгисийн  
нөөцийг хамгаалах,  
нөөцийг тогтвортой  
хөгжилд зүй зохистой  
ашиглах

*Таны оролцоо: Гол мөрөн ба нуурууд нь цэвэр усны  
үнэт эх үүсвэр юм. Эдгээрийг цэвэр байлгаж хамгаал.*





ТОГТВОРТОЙ  
ХӨГЖЛИЙН

ЗОРИЛГУУД

## 15 ХУУРАЙ ГАЗРЫН ЭКОСИСТЕМИЙГ ХАМГААЛАХ



Хуурай газрын экологийн системийг хамгаалах, нөхөн сэргээх, зүй зохистой ашиглах, ойн нөөцийн тогтвортой байдлыг хангах, цөлжилттэй тэмцэх, газрын доройтлыг бууруулах, биологийн олон янз байдлыг мөхөж устахаас сэргийлэх

*Таны оролцоо: Нэн ховордсон ан амьтадыг болон тэдний амьдрах орчныг хамгаал.*



ТОГТВОРТОЙ  
ХӨГЖЛИЙН

ЗОРИЛГУУД

## 16 ЭНХ ТАЙВАН, ШУДАРГА ЁСЫГ ЦОГЦЛООХ



Амгалан тайван, бүх нийтийн оролцоог хангасан хууль ёст тогтвортой хөгжлийн нийгмийг бүрдүүлж, үр нөлөөтэй, хариуцлагатай, оролцоо бүхий чадварлаг институцийг бүх шатанд бий болгох

*Таны оролцоо: Өөрийн улс орон ба орон нутгийн шийдвэр гаргагчдаа сонгохдоо өөрийн сонгох эрхээ ашигла.*



ТОГТВОРТОЙ  
ХӨГЖЛИЙН

ЗОРИЛГУУД

**17** ХӨГЖЛИЙН  
ТӨЛӨӨХ  
ТҮНШЛЭЛИЙГ  
БЭХЖҮҮЛЭХ



Тогтвортой хөгжлийн  
төлөөх дэлхий нийтийн  
түншлэлийг эрчимжүүлж,  
хэрэгжүүлэх арга  
механизмыг бүрдүүлэх

*Таны оролцоо: “Тогтвортой хөгжлийн зорилгууд”-ын  
талаар мэдэж аваад бусдад энэ талаар хэлж өг.*


*<http://www.un.-mongolia.mn/>*





**MONGOLIA**

📍 Монгол дахь Нэгдсэн Үндэстний Байгууллага  
Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг  
Нэгдсэн Үндэстний гудамж 14  
НҮБ-ын байр - 14201

☎ Утас: 976 11 327585,  
Факс: 976 11 326221

 /unmongolia

 /unmongolia

 [www.un-mongolia.mn](http://www.un-mongolia.mn)

